

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН  
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)	Гүйцэтгэлийн хувь
					Хагас жил		
<b>Зорилго 1.</b> Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ.							
<b>Зорилт 1.2.</b> Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана.							
1.1.1	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	-	Дүн шинжилгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь	8 удаагийн зөвлөгөө өгөх сургалт зохион байгуулсан.	Цахим өгөгдөлд хийсэн дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	Лавлагаа шатлалын эмнэлгүүдэд эхний 4 сарын байдлаар нийт 169,2 сая төгрөгийн буюу нийт нэхэмжлэлийн 2 % нь, анхан шатны эрүүл мэндийн төвүүдэд 48,3 сая төгрөг буюу нийт нэхэмжлэлийн 1,8 % нь цахимаар хасагдаж байна. Өнгөрсөн оны байдлаар лавлагаа шатлалын цахим хасалт 3.4%, анхан шатны цахим хасалт 0.2% байсан байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын цахим хасалт өнгөрсөн жилээс эрс нэмэгдсэн гол шалтгаан нь сарын төсвийн хуваарийг хэтрүүлж нэхэмжлээд байгаа явдал бөгөөд гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад тухай бүр мэдээлж сарын төсвийн хуваариа мөрдөж ажиллахыг анхааруулж байна. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад цахим хасалт өнгөрсөн оны үеэс буурсан бөгөөд сонгосон оношийн хамааралтай бүлгийн үйлдлийн кодоо зөв бичдэг болсон, ЭМД-ын шимтгэл төлөлтийг маш сайн шалгадаг, яаралтай тусламж үйлчилгээ авсны дараа эмнэлэгт хэвтэж байгаа даатгуулагчийн зардлыг нэхэмжлэхээ больсонтой холбоотой. Чанар, төлбөрийн хяналт хийх явцад анхан шатны эрүүл мэндийн байгууллагад яаралтай тусламж үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийг буруу сонгож бүртгэх тохиолдол маш их байсан учир анхан шатны эрүүл мэндийн байгууллагын нийт 142 эмч сувилагч нарт яаралтай тусламжийн	100%

						оношийн хамааралтай бүлгийг хэрхэн сонгож бүртгэх талаар онлайн-аар мэдээлэл өгсөн.	
1.1.2	Эрүүл мэндийн даатгалын 2022, 2023, 2024 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийн эмхэтгэлийг гэрээт эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд түгээн сурталчилна.	-	Мэдээллээр хангасан ЭМБ, иргэдийн тоо	-	Статистик мэдээллийг олон нийтэд түгээн сурталчилах арга хэмжээг зохион байгуулсан байна.	2022, 2023, 2024 оны үйл ажиллагааны тайлан статистик мэдээллийн эмхэтгэл нэгтгэгдсэн байдлаар ирээгүй. Аймгийн хэмжээнд гэрээтэй ажилладаг эрүүл мэндийн байгууллагуудын 2024 оны гүйцэтгэлийн санхүүжилтийн мэдээг аймгийн ЭМГ, аудитын газар, аймгийн ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтэс, татварын газарт хүргүүлсэн. 2025 гарсаар сар бүрийн хянагдсан гүйцэтгэл, түүнд олгох болон олгосон санхүүжилтийн мэдээг аймгийн ИТХ-д албан тоотоор 5 сараас эхлэн хүргүүлж байна. Мөн хэлтсийн нүүр номын хуудсаар болон хэлтсийн байрны гадна байдаг сурталчилгааны самбарт мэдээллийг тавьж сурталчилж байна. Сар болгоны ЭМБ-уудаас ирүүлсэн нэхэмжлэлийн болон олгох санхүүжилтийн дүнг аймгийн статистикийн хэлтэст хүргүүлж аймгийн сарын мэдээний товхимолд оруулдаг.	70%
1.1.3	"Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.	-	- Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо - Хяналт тавьж ажилласан ЭМБ-ын тоо	ЭМДҮЗ-ийн 2024 оны 06,14 дүгээр тогтоолыг гэрээт 33 эрүүл мэндийн байгууллагад танилцуулан, хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан.	Шинэчлэгдсэн журмыг ЭМБ-дад танилцуулж, хяналт тавин ажилласан байна.	ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоолыг лавлагаа шатлалын 7 гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, тогтоолын мөрөөр нийт 1 удаагийн танхимын, 1 удаагийн онлайн сургалтыг зохион байгуулж танхимаар 34, онлайн-аар 90 орчим эмч мэргэжилтнүүдийг хамруулсан. БТГ-аас зохион байгуулсан шинэчилсэн тогтоолыг танилцуулах 2 удаагийн онлайн сургалтанд хувийн 5 эмнэлэг, улсын 2 эмнэлгийн эмч мэргэжилтнүүдийг хамруулсан.	100%

1.1.4	ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.	-	-Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо, -Хяналт тавин ажилласан ЭМБ тоо	ЭМДҮЗ 2024 оны 05 дугаар тогтоолыг мөрдөж байна. Гэрээ бүхий 26 анхан шатны ЭМБ-д хүргэн ажиллалаа	Шинэчлэгдсэн журмыг ЭМБ-дад танилцуулж, хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг тайлагнасан байна.	ЭМДҮЗ-ийн 2025 оны 03 дугаар тогтоолыг анхан шатны 26 өрх сум тосгоны эрүүл мэндийн төв, 04 дүгээр тогтоолыг 21 сум тосгоны эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлж, тогтоолын мөрөөр 1 удаагийн онлайн сургалтыг аймгийн ЭМГ-тай хамтран зохион байгуулж 200 орчим эмч мэргэжилтнүүдийг хамруулсан. Энэ тогтоол 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн хэрэгжсэн бөгөөд тогтоолтой холбоотой цахим програмд гарч байгаа өөрчлөлтүүдийг гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад тухай бүр мэдээлж байна. БТГ-аас зохион байгуулсан шинэчилсэн тогтоолыг танилцуулах 2 удаагийн онлайн сургалтанд өрх сум тосгоны 26 эрүүл мэндийн төвийн эмч мэргэжилтнүүдийг хамруулсан.	100%
1.1.5	Даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд хамруулсан эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана.	-	-Санхүүжүүлсэн мөнгөн дүн -Хамрагдсан даатгуулагчийн тоо	ЭМДҮЗ-ийн 2023 оны 10 дугаар тогтоолыг мөрдөж байна. 2024 онд 12989 иргэн хамрагдаж 1679,2 сая төгрөгийн санхүүжилт олгосон.	Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж, гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-уудын гүйцэтгэлд хяналт хийж, санхүүжилтийг баталгаажуулсан байна.	Даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд хамруулахаар тус аймагт аймгийн нэгдсэн эмнэлэг, Мандал сумын нэгдсэн эмнэлэг гэрээтэй ажилладаг бөгөөд 18-30 насны багцаар Сайхан сумын ЭМТөвд 2024 оны 01 дүгээр сард газар дээрх хяналтыг хийж гэрээнд өөрчлөлт оруулсан, эмнэлэг өөрсдөө програмын бэлэн байдал хангаагүй байгаа учраас одоо болтол энэ тусламж үйлчилгээг үзүүлж эхлээгүй байна. 2025 оны эхний 4 сарын байдлаар гэрээтэй 2 эмнэлгээс эрт илрүүлгийн зардалд нийт 1486 даатгуулагчийн 271.770.000 төгрөгийн гүйцэтгэл ирүүлснээс 1469 даатгуулагчийн 267.960.000 төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.	100%
1.1.6	ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд нөлөөлж буй	-	-Хийсэн дүн шинжилгээний тоо -Бодлого төлөвлөлтийн	3 удаа дүн шинжилгээ хийгдэж 5 санал	Хагас жил тутам дүн шинжилгээ хийж, санал боловсруул	Анхан шатны тусламж үйлчилгээнд тусламж үйлчилгээг давхардуулан авахаас бусад цахим шалгуур ажиллахгүй байгаагаас анхан шатны тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг хянахад цаг	100%

	хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлнэ.		газарт хүргүүлсэн саналын тоо	хүргүүлсэн	ан Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна.	хугацаа гар ажиллагаа их орж байгааг үндэслэн цахимаар хянаж болох 5 шалгуурын саналыг БТХ-т хүргүүлсэн. Одоо болтол програмын цахим хяналтад нэвтрээгүй байна. 2025 оны 04 дүгээр тогтоолын хэрэгжилт эхэлснээс хойш архаг тусламж үйлчилгээний тоо хэмжээг хязгаарласнаар оношийн код хувиргах тохиолдол 4 сарын түүвэр хянаж байхад ажиглагдаж эхэлж байна. Код хувиргасан тохиолдлуудыг одоогийн байдлаар бүртгэж авах ажлыг хийж байна.	
1.1.7	"ЭМДС-аас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ"-ний жагсаалтыг шинэчлэн баталсан ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана.	-	Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо -Хяналт тавьж ажилласан ЭМБ-ын тоо	ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолыг мөрдөж байна.	Шинэчлэгдсэн журмыг ЭМБ-дад танилцуулж, хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг холбогдох нэгжид тайлагнасан байна.	Өнөөдрийн байдлаар ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолоор баталсан ЭМДС-аас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг мөрдөж ажиллаж байгаа бөгөөд новартис хөтөлбөр дууссантай холбоотой жагсаалтаас хасагдсан байсан тодорхой нэр төрлийн эмүүдийг буцааж жагсаалтанд нэмсэн тухай гэрээт эмийн сангуудад мэдээлсэн. 2025 оны эхэнд хуучин байсан 35 эмийн сантай гэрээ байгуулж нэмэлтээр 3 эмийн сантай шинээр гэрээ байгуулан одоогийн байдлаар 38 эмийн сантай гэрээтэй ажиллаж байна. Гэрээ байгуулсан 1 эмийн санд одоогийн байдлаар гүйцэтгэл гараагүй байгаа тул 2025 оны эхний 4 сарын байдлаар нийт 37 эмийн сангийн 31826 даатгуулагчдад хөнгөлөлттэй эмээр үйлчилсэн 1.137.973.985 төгрөгийг олгохоор гүйцэтгэлийг санхүү бүртгэлийн хэлтэст шилжүүлсэн.	100%
Зорилт 1.4. Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно:							
1.2.1	Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал өгнө.	-	Хүргүүлсэн саналын тоо	ЭМС-ын 2019 оны 611 дүгээр тушаалд өөрчлөлт	Эрх зүйн баримт бичигт холбогдох саналыг боловсруулж	Нэхэмжлэлийн хяналтын журамд 4, орлого хүлээн авах журамд 5, хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газартай байгуулах гэрээнд 2, улсын байцаагчийн эрх олгох журамд 2, эрүүл мэндийн	100%

				<p>оруулах 10 санал, ЭМДҮЗ-ийн 2023 оны 06, 08 дугаар тогтоолд өөрчлөлт оруулахад 2 санал, анхан шатны үндсэн тусламж үйлчилгээний шалгуурт 13 санал, цахим 5 шалгуурын санал, 2024 оны 05 болон 06 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах 7 саналыг БТГ-т хүргүүлсэн.</p>	<p>хүргүүлсэн байна.</p>	<p>даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах 10 саналыг холбогдох газар хэлтэст хүргүүлсэн.</p>	
1.2.2	<p>Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, Прокурорын байгууллагатай хамтран ажиллана.</p>	-	<p>Зөрчлийн хэргийн тоо</p>	<p>2024 оны аймгийн Прокурорын байгууллагатай хамтран гэмт хэрэгт холбогдсон 234 хүний судалгааг гарган өгч санд 30.6 сая төгрөг төвлөрүүлсэн</p>	<p>Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байна.</p>	<p>Цагдаагийн байгууллагатай хамтран гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрүүл мэнд нь хохирсон даатгуулагчийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын төлбөрийг холбогдох хууль хяналтын байгууллага хариуцан буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн цагдаагийн газарт нийт 103 иргэний 91.901.211 төгрөгний тодорхойлолт гаргаж өгснөөс одоогийн байдлаар 15 иргэний 2.776.140 төгрөгийг ЭМД-ын санд төлүүлсэн байна. Сэлэнгэ аймгийн шүүхийн шийдвэр биелүүлэх газартай тооцоо нийлсэн акт үйлдэж нийт ... даатгуулагчийн ... төгрөг төлөгдөөгүй байгааг тогтоосон.</p>	<p>70% Далайгийн хувь орсон эсэх</p>

**Зорилго 2: Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөнө.**

**Зорилт 2.1. Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусламж, үйлчилгээний тоо хэмжээг нэмэгдүүлнэ.**

2.1.1	Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.	-	Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь	2024 оны хамрагдалтын хувь 53.2	2025 онд 60 хувиас дээш хамруулна.	2025 оны 04 сарын 30-ны байдлаар 685 малчин хамрагдахаас 802 малчин хамрагдаж эрүүл мэндийн даатгалын шимтгэлд 85.973.020 төгрөг төлснөөр хамралтын хувь – <b>117%</b>	100%
			Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь	2024 оны хамрагдалтын хувь 800.7	2025 онд 90 хувиас дээш хамруулна.	2025 оны 04 сарын 30-ны байдлаар 403 оюутан хамрагдахаас 2084 оюутан хамрагдаж эрүүл мэндийн даатгалын шимтгэлд 161.581.700 төгрөг төлснөөр хамралтын хувь – <b>517%</b>	
			Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь	2024 оны хамрагдалтын хувь 74.8	2025 онд 85 хувиас дээш хамруулна.	2025 оны 04 сарын 30-ны байдлаар 3160 тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн хамрагдахаас 2171 иргэн хамрагдаж эрүүл мэндийн даатгалын шимтгэлд 198.864.780 төгрөг төлснөөр хамралтын хувь – <b>68,7%</b>	
			Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын хувь	2024 оны хамрагдалтын хувь 100	2025 онд 100 хувиас дээш хамруулна.	2025 оны 04 сарын 30-ны байдлаар Сэлэнгэ аймгийн хэмжээнд нийт 1296 ажил олгогчийн 18861 ажилтныг хамруулахаас 15300 даатгуулагчийн 6229,1 сая төгрөгийг эрүүл мэндийн таатгалын санд төвлөрүүлсэн байна. Хамралтын хувь – <b>81,1%</b>	
2.1.2	Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж тайлан, мэдээг гарган холбогдох нэгжид хүргүүлнэ.	-	Нэгтгэн хүргүүлсэн тайлангийн тоо	2024 онд сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, тайлан мэдээг гарган жилд 3 удаа	Тайлан, мэдээг хугацаанд нь, үнэн зөв гарган 4 удаа хүргүүлсэн байна.	2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 1 сард журамд заасан хугацаанд алдаа мадаггүй үнэн зөв гаргаж, гэрээт бүх эрүүл мэндийн байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үлйдэж актуудын хамт санхүү бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн. Анхан болон лавлагаа шатлалын эмнэлгүүдтэй сарын төсвийн хуваарийн хэлцлийг бүрэн хийж дуусаагүйгээс 3 сарын зарим тусламж	70%

				ЭМДЕГ-т хүргүүлсэн.		үйлчилгээний гүйцэтгэл хүргэгдээгүй учир I улирлын санхүүгийн тайлан гарч дуусаагүй байна.																																	
2.1.3	Эрүүл мэндийн даатгалын төсвийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт зардлын гүйцэтгэлийг хангуулж, тайлагнана.		Төвлөрүүлсэн мөнгөн дүн	2024 онд орлогын төлөвлөгөөний биелэлт 93.7 хувьтай.	ЭМД-ын орлогын төлөвлөгөөний биелэлтийг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.	<p>ЭМДҮЗ-ийн 2025 оны 01 дүгээр тогтоолоор баталсан орлогын төлөвлөгөөний дагуу 2025 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар орлогын төлөвлөгөөний биелэлт <b>77,8%</b> байна.</p> <table border="1"> <thead> <tr> <th rowspan="2">Сар</th> <th rowspan="2">Төлөвлөгөө</th> <th colspan="2">Биелэлт</th> <th rowspan="2">Хувь</th> </tr> <tr> <th>Ажил олгогч</th> <th>Хувиараа төлөх</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>2145,4</td> <td>1013,4</td> <td>123,8</td> <td>53%</td> </tr> <tr> <td>2</td> <td>2145,4</td> <td>1472,1</td> <td>86,9</td> <td>72,6%</td> </tr> <tr> <td>3</td> <td>2145,4</td> <td>1956,3</td> <td>108,9</td> <td>96,3%</td> </tr> <tr> <td>4</td> <td>2145,4</td> <td>1787,3</td> <td>126,8</td> <td>89,2%</td> </tr> <tr> <td><b>НИЙТ</b></td> <td><b>8581,6</b></td> <td><b>6229,1</b></td> <td><b>446,4</b></td> <td><b>77,8%</b></td> </tr> </tbody> </table> <p>Аймгийн НДГ 2024 оны 1 сараас эхлэн төвлөрсөн орлогоо өөрсдөө санд хуваарилахаа болиод шууд НДЕГ-ын төвлөрсөн дансанд төвлөрүүлдэг болсноор өөрийн аймгийн НДГ яг хэдэн төгрөгний шимтгэлийн орлогыг эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлж байгааг тодорхой гаргах боломжгүй болсон.</p>	Сар	Төлөвлөгөө	Биелэлт		Хувь	Ажил олгогч	Хувиараа төлөх	1	2145,4	1013,4	123,8	53%	2	2145,4	1472,1	86,9	72,6%	3	2145,4	1956,3	108,9	96,3%	4	2145,4	1787,3	126,8	89,2%	<b>НИЙТ</b>	<b>8581,6</b>	<b>6229,1</b>	<b>446,4</b>	<b>77,8%</b>	78%
Сар	Төлөвлөгөө	Биелэлт		Хувь																																			
		Ажил олгогч	Хувиараа төлөх																																				
1	2145,4	1013,4	123,8	53%																																			
2	2145,4	1472,1	86,9	72,6%																																			
3	2145,4	1956,3	108,9	96,3%																																			
4	2145,4	1787,3	126,8	89,2%																																			
<b>НИЙТ</b>	<b>8581,6</b>	<b>6229,1</b>	<b>446,4</b>	<b>77,8%</b>																																			
<b>Зорилт 2.2. Даатгалын сангийн тогтвортой байдлыг хангаж, эрсдэлээс хамгаална.</b>																																							
2.2.1	Өглөг, авлага үүсгэхгүй ажиллана. Авлага барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авна.	ЭМДС	Өглөг, авлагын тоо хэмжээ, тайлан	2024 онд 6485,9 сая төгрөгийн өглөгтэй тайланг ЭМДЕГ-т хүргүүлсэн.	Өглөг, авлага барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласан байна.	2024 оны жилийн эцэст үүссэн өглөгийг оны эхний улиралд багтаан гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад бүрэн олгосон. 2025 оны 05 сарын 22-ны байдлаар сумын эрүүл мэндийн төвүүдэд 40.8 сая төгрөгийг өглөгтэй байна.	70%																																
<b>Зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна</b>																																							
<b>Зорилт 3.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна.</b>																																							

3.1.1	Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, эмийн сангуудын 2024 оны гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулна.	-	Гэрээ дүгнүүлсэн байгууллагын тоо	2024 онд 69 гэрээт ЭМБ-ыг дүгнэсэн	Гэрээт ЭМБ-уудын гэрээг хагас, бүтэн жилээр хугацаанд нь дүгнэж, холбогдох арга хэмжээний саналыг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн байна. Гэрээний биелэлтийн хувь 90 хувиас доошгүй.	Улсын 2 эмнэлэг, хувийн 5 эмнэлэг, өрх сум тосгоны 26 эрүүл мэндийн төв, 36 эмийн сан нийт 69 эрүүл мэндийн байгууллагын 2024 оны гэрээг дүгнэж холбогдох тайланг, баталгаажсан үнэлгээний хуудсын хамт хугацаанд нь ХАГГ-т хүргүүлсэн. Эмийн сангийн гэрээний хэрэгжилтийн дундаж 91,7% анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын гэрээний хэрэгжилтийн дундаж 79,3%, лавлагаа шатлалын эмнэлгүүдийн гэрээний хэрэгжилтийн дундаж 76,3%. Нийт 69 эрүүл мэндийн байгууллагуудын гэрээний хэрэгжилтийн дундаж 82,4% байна.	100%
3.1.2	2025 онд Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ, даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх гэрээг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулах үйл ажиллагааг зохион байгуулна.	-	Шинэчлэн байгуулсан гэрээний тоо	Өрхийн ЭМТ-5, Сумын ЭМТ-26, Эмийн сан-38 Лавлагаа шатлалын эмнэлэг-7	Гэрээний дүгнэлтээр хангалттай үнэлэгдсэн, шинээр хүсэлт ирүүлсэн ЭМБ-уудтай гэрээ байгуулагдсан байна.	2024 оны гэрээг хангалттай дүгнүүлсэн 2 улсын эмнэлэг, 5 хувийн эмнэлэг, сум тосгоны 21 эрүүл мэндийн төв, өрхийн 5 эрүүл мэндийн төв, 35 эмийн сантай 2025 онд тусламж үйлчилгээг худалдан авах гэрээг байгуулж, хугацаанд нь ХАГГ-т хүргүүлсэн. Шинээр гэрээ байгуулсан 3 эмийн сангийн гэрээг байгуулж хүргүүлсэн. Анхан болон лавлагаа шатлалын эмнэлгүүдтэй тусламж үйлчилгээг худалдан авах төсвийн талаар хэлцэл хийж тухайн эмнэлгийн жилийн нийт төсвийг танилцуулан, сарын гүйцэтгэлийн төсвийн хуваарийг эрүүл мэндийн байгууллагуудаар өөрсдөөр нь хийлгүүлж баримтыг ХАГГ-т хүргүүлсэн. Лавлагаа шатлалын 7 эмнэлэгтэй гэрээг цахим гарын үсгээр баталгаажуулж хүргүүлсэн.	100%

3.1.3	Чанар, төлбөрийн хяналтын журамд орсон өөрчлөлтийн талаар гэрээт эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Мэдээллээр хангасан ЭМБ-ын тоо, хэрэгжилтийн тайлан	Лавлагаа шатлалын гэрээт 7, анхан шатны 26 эрүүл мэндийн байгууллагыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг тайлагнасан.	Журамд орсон өөрчлөлтийг лавлагаа шатлалын улсын эмнэлэг, гэрээт хувийн хэвшлийн эмнэлэг, анхан шатны ЭМБ-уудад танилцуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж тайлагнасан байна.	ЭМДЕГ-ын даргын А/30 тушаалаар баталсан нэхэмжлэлийг хянах журмыг хүлээж авч гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад танилцуулсан. Тус журмын 4 дүгээр хавсралтад заасан баталгаажуулах хуудсын дагуу хасагдлын тайлан мэдээг гаргаж НХХ-т хүргүүлсэн	100%																																	
Зорилт 3.2. Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна																																								
3.2.1	Олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурыг үндэслэн гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.	-	Гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-ын тоо, нэхэмжилсэн даатгуулагчийн тоо, мөнгөн дүн	Нийт 28 ЭМБ-д 24.7 тэрбум төгрөгийн нэхэмжлэлийн гүйцэтгэл хянагдсан.	Хуваарилагдсан түүвэрт нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг хугацаанд нь журмын дагуу хэрэгжүүлсэн байна.	<p>Тус хэлтсийн мэргэжилтнүүдэд оны эхний 4 сарын байдлаар нийт 7560 түүвэр унаснаас 7474 түүврийг хянаж, анхан шатны баримт ирүүлээгүй 86 тохиолдлыг хяналт хийгээгүй хассан байна. Нийт 5659,9 сая төгрөгний түүвэр хянаснаас 783 тохиолдлын 33,1 сая төгрөгний гүйцэтгэлийг чанарын хяналт хийж хассан нь нийт түүвэр хийсэн тохиолдлын 10,5%, мөнгөн дүнгийн 0,6%-ийг эзэлж байна.</p> <table border="1" data-bbox="1328 1061 1919 1345"> <thead> <tr> <th rowspan="2">Мэргэжилтний нэр</th> <th colspan="2">Түүвэр</th> <th rowspan="2">Анхан шатны баримт ирүүлээгүй</th> <th colspan="3">Хассан</th> </tr> <tr> <th>Тоо</th> <th>Дүн /сая,т өг/</th> <th>Тоо</th> <th>Дүн /сая,т өг/</th> <th>Хувь</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Дэлгэр</td> <td>1802</td> <td>1504,7</td> <td>9</td> <td>200</td> <td>166,9</td> <td>11,1</td> </tr> <tr> <td>Далайбаатар</td> <td>2673</td> <td>3771,9</td> <td>-</td> <td>14</td> <td>26,2</td> <td>0,7</td> </tr> <tr> <td>Эрдэнэцэцэг</td> <td>3085</td> <td>383,3</td> <td>77</td> <td>569</td> <td>81,5</td> <td>21,3</td> </tr> </tbody> </table>	Мэргэжилтний нэр	Түүвэр		Анхан шатны баримт ирүүлээгүй	Хассан			Тоо	Дүн /сая,т өг/	Тоо	Дүн /сая,т өг/	Хувь	Дэлгэр	1802	1504,7	9	200	166,9	11,1	Далайбаатар	2673	3771,9	-	14	26,2	0,7	Эрдэнэцэцэг	3085	383,3	77	569	81,5	21,3	100%
Мэргэжилтний нэр	Түүвэр		Анхан шатны баримт ирүүлээгүй	Хассан																																				
	Тоо	Дүн /сая,т өг/		Тоо	Дүн /сая,т өг/	Хувь																																		
Дэлгэр	1802	1504,7	9	200	166,9	11,1																																		
Далайбаатар	2673	3771,9	-	14	26,2	0,7																																		
Эрдэнэцэцэг	3085	383,3	77	569	81,5	21,3																																		

					<p>Сэлэнгэ аймгийн гэрээтэй 7 лавлагаа шатлалын эмнэлгийн гүйцэтгэлд 21 аймаг, 45 мэргэжилтэн хяналт хийж нийт 1776 түүвэр унаснаас 1773 тохиолдлыг хянаж 3 тохиолдлыг анхан шатны баримт ирүүлээгүй шалтгаанаар хасч, 455 тохиолдолд чанарын хяналт хийж хассан байна. Сэлэнгэ аймгийн хэмжээнд гэрээтэй ажиллаж байгаа 2 улсын эмнэлэг, 5 хувийн эмнэлэг, 26 өрх сум, тосгоны эрүүл мэндийн төв, 38 эмийн сангийн эхний 4 сарын гүйцэтгэлд хяналт хийж нийт 135153 даатгуулагчийн 12255,0 сая төгрөг нэхэмжилснээс 131341 даатгуулагчийн 11462,6 сая төгрөгийг олгуулахаар санхүү бүртгэлийн хэлтэст хүргүүлээ.</p> <table border="1"> <thead> <tr> <th rowspan="2">ЭМБ</th> <th colspan="2">нэхэмжилсэн</th> <th colspan="2">хассан</th> <th colspan="2">олгосон</th> </tr> <tr> <th>Хүний н тоо</th> <th>Мөнгө н дүн</th> <th>Хүний н тоо</th> <th>Мөнгө н дүн</th> <th>Хүний н тоо</th> <th>Мөнгө н дүн</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Улс/э м</td> <td>75,316</td> <td>7,587,969,721</td> <td>1,828</td> <td>526,321,144</td> <td>73,488</td> <td>7,061,648,577</td> </tr> <tr> <td>ТХ эм</td> <td>704</td> <td>32,025,770</td> <td>-</td> <td>40,200</td> <td>704</td> <td>31,985,570</td> </tr> <tr> <td>Эрт/и л</td> <td>1,486.00</td> <td>271,770,000.00</td> <td>17.00</td> <td>3,810,000.00</td> <td>1,469.00</td> <td>267,960,000.00</td> </tr> <tr> <td>Эмий н сан</td> <td>31,826.00</td> <td>1,138,311,344.00</td> <td></td> <td>337,359.00</td> <td>31,826.00</td> <td>1,137,973,985.00</td> </tr> <tr> <td>Хув/э м</td> <td>3,612.00</td> <td>752,012,015.00</td> <td>84.00</td> <td>30,604,381.00</td> <td>3,528.00</td> <td>721,407,634.00</td> </tr> <tr> <td>Анх/х уучин</td> <td>9,172.00</td> <td>446,504,500.00</td> <td>1,056.00</td> <td>44,905,500.00</td> <td>8,116.00</td> <td>401,599,000.00</td> </tr> <tr> <td>Анх/ш инэ</td> <td>13,037.00</td> <td>2,026,477,521.00</td> <td>827.00</td> <td>186,405,291.00</td> <td>12,210.00</td> <td>1,840,072,230.00</td> </tr> <tr> <td><b>НИЙТ</b></td> <td><b>135,153</b></td> <td><b>12,255,070,871</b></td> <td><b>3,812</b></td> <td><b>792,423,875</b></td> <td><b>131,341</b></td> <td><b>11,462,646,996</b></td> </tr> </tbody> </table>	ЭМБ	нэхэмжилсэн		хассан		олгосон		Хүний н тоо	Мөнгө н дүн	Хүний н тоо	Мөнгө н дүн	Хүний н тоо	Мөнгө н дүн	Улс/э м	75,316	7,587,969,721	1,828	526,321,144	73,488	7,061,648,577	ТХ эм	704	32,025,770	-	40,200	704	31,985,570	Эрт/и л	1,486.00	271,770,000.00	17.00	3,810,000.00	1,469.00	267,960,000.00	Эмий н сан	31,826.00	1,138,311,344.00		337,359.00	31,826.00	1,137,973,985.00	Хув/э м	3,612.00	752,012,015.00	84.00	30,604,381.00	3,528.00	721,407,634.00	Анх/х уучин	9,172.00	446,504,500.00	1,056.00	44,905,500.00	8,116.00	401,599,000.00	Анх/ш инэ	13,037.00	2,026,477,521.00	827.00	186,405,291.00	12,210.00	1,840,072,230.00	<b>НИЙТ</b>	<b>135,153</b>	<b>12,255,070,871</b>	<b>3,812</b>	<b>792,423,875</b>	<b>131,341</b>	<b>11,462,646,996</b>
ЭМБ	нэхэмжилсэн		хассан		олгосон																																																																					
	Хүний н тоо	Мөнгө н дүн	Хүний н тоо	Мөнгө н дүн	Хүний н тоо	Мөнгө н дүн																																																																				
Улс/э м	75,316	7,587,969,721	1,828	526,321,144	73,488	7,061,648,577																																																																				
ТХ эм	704	32,025,770	-	40,200	704	31,985,570																																																																				
Эрт/и л	1,486.00	271,770,000.00	17.00	3,810,000.00	1,469.00	267,960,000.00																																																																				
Эмий н сан	31,826.00	1,138,311,344.00		337,359.00	31,826.00	1,137,973,985.00																																																																				
Хув/э м	3,612.00	752,012,015.00	84.00	30,604,381.00	3,528.00	721,407,634.00																																																																				
Анх/х уучин	9,172.00	446,504,500.00	1,056.00	44,905,500.00	8,116.00	401,599,000.00																																																																				
Анх/ш инэ	13,037.00	2,026,477,521.00	827.00	186,405,291.00	12,210.00	1,840,072,230.00																																																																				
<b>НИЙТ</b>	<b>135,153</b>	<b>12,255,070,871</b>	<b>3,812</b>	<b>792,423,875</b>	<b>131,341</b>	<b>11,462,646,996</b>																																																																				
3.2.2	Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.	-	Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо	2024 онд 33 ЭМБ-д зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.	Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан зөвлөн туслах	ЭМДҮЗ-ийн 2025 оны 03, 04 дүгээр тогтоолууд хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой гэрээтэй эрүүл мэндийн байгууллагын эмч сувилагч нарт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж програм дээр гарч буй																																																																				

					үйлчилгээг үзүүлсэн байна.	алдаа манай байгууллагатай холбоотой бол тухай бүр МТХ болон БТГ, ХАГГ-тай холбогдон засуулж байна. 6 настны эрт илрүүлэг эхэлсэнтэй холбоотой шүдний үзлэг, эмчилгээ, зүрхний бичлэг хийсэн тухай програмд хэрхэн шивэх тухай бичлэгийг тайлбарлаж өгсөн. Сар бүрийн гүйцэтгэлийг хянаж байхад гарч буй алдаа, анхан шатны баримт бүрдүүлэхэд анхаарах асуудлыг тухай бүр хариуцсан мэргэжилтэнд болон гэрээт эрүүл мэндийн байгууллагуудтай харилцдаг групп чатад хэлж, бичиж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллаж байна.	100%
3.2.3	Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд ЭМД-ын улсын байцаагч (ахлах)-ийн зөвлөмжийг тухай бүр хүргүүлж, биелэлтийг хангуулна.	-	Хүргүүлсэн зөвлөмжийн тоо Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	2024 онд нийт 22 зөвлөмж хүргүүлсэн.	Тусламж, үйлчилгээний чанар хэрхэн сайжирсан талаарх тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна.	Гэрээ бүхий лавлагаа шатлалын 5 эмнэлэгт 2024 оны 07-12 сарын нэхэмжлэлийн хяналтад үндэслэж улсын ахлах байцаагчийн 5 зөвлөмжийг хүргүүлсэн. ЭБУС болон Асгатын дов эмнэлэгт нэхэмжлэлийн хяналтаар алдаа зөрчилтэй тохиолдол бүртгэгдээгүй учир зөвлөмж хүргүүлээгүй. Нийт хүргүүлсэн зөвлөмжийн тоо – 5.	100%
3.2.4	Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон даатгуулагчдын гомдол, саналд үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт шалгалт хийнэ.	-	Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо -Хяналт шалгалтын тайлан	2024 онд гэрээт 5 байгууллагад газар дээрхи хяналт шалгалтыг зохион байгуулсан.	Газар дээрх хяналт, шалгалт хийж, тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна.	Хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу оны эхний 4 сарын хугацаанд нийт 5 удаагийн газар дээрх хяналт хийж тайланг хугацаанд нь ХАГГ-т хүргүүлсэн. Орхонтуул сумын ЭМТ болон Ачит амирлуулагч өрхийн ЭМТ-д оношилгоо шинжилгээний, Зүүнбүрэн, Жавхлант, Ерөө, Орхонтуул сумын ЭМТ-д шүдний тусламж үйлчилгээний, аймгийн нэгдсэн эмнэлэгт хорт хавдрын үеийн химийн бай эмчилгээний хэвтэн болон өдрийн эмчилгээний гэсэн 2 оношийн хамааралтай бүлэг дээр газар дээрх хяналт хийж, хүний нөөц, техник тоног	100%

						төхөөрөмж хангалтгүй учир Ачит амирлуулагч өрхийн ЭМТ-д оношилгоо шинжилгээний тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлага хангахгүй гэсэн дүгнэлт гаргаж бусад тохиолдолд энэ оны батлагдсан төсвийн хүрээнд тусламж үйлчилгээ үзүүлэхээр нэмэлт гэрээ байгуулан ажиллаж байна.	
<b>Зорилго 4: Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.</b>							
<b>Зорилт 4.1. Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө.</b>							
4.1.1	Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэлтэс, албан хаагчдад чиглэсэн арга хэмжээг орон нутагтай хамтарч хэрэгжүүлнэ.	-	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, тайлан	Засгийн газрын 2023 оны 272-р тогтоолын дагуу орон нутаг ажилласны нэмэгдлийг үндсэн цалингийн 20 хувиар тооцож 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэлтсийн нийт ажилтнуудад олгож байна.	Орон нутгийн удирдлагатай хамтран арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.	Хэлтсийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор ерөнхий газраас 3 шинэ компьютер, 3 нэмэлт дэлгэц, 3 үйлдэлтэй шинэ принтер, 1 шинэ сандал шийдэж өгснөөр ажлын бүтээмж дээшилж, ажлын байрны өнгө төрх сайжирсан. Мөн хэлтэст шинэ нөүтбүүк өгснөөр хуучин нөүтбүүкийг Мандал суман дахь чанар төлбөрийн хяналтын мэргэжилтэнд шилжүүлж өгснөөр сургалт сурталчилгаа хийхэд тус дэмтэй болсон. Орон нутгаас хэлтсийн мэргэжилтнүүдэд орон нутгийн нэмэгдэл цалин 30 хувийг 2024 оны 04 дүгээр сарын 01-нээс тогтмол олгож байна. Хүүхэд асрах чөлөөнөөс ажилдаа орсон чанар төлбөрийн хяналтын мэргэжилтэн мөн 5 сараас эхлэн ажилласан хугацаандаа тохируулан орон нутгийн нэмэгдлийг авч эхэлж байна. Төрийн алба хаасан хугацаа нь шаардлага хангасан 1 чанар төлбөрийн хяналтын мэргэжилтэн төрийн албан хаагчийн 5 жилийн тэтгэмжээ авах эрх үүсч түүнийг олгох тухай тушаал гарсан. Мөн 1 мэргэжилтэн эрх үүсч холбогдох бичиг баримтаа хүргүүлсэн байна.	100%
4.1.2	ЭМДЕГ-аас баталсан Сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион	-	Хамрагдсан сургалтын тоо	ЭМДЕГ-аас зохион байгуулсан 12 удаагийн	Ерөнхий газраас зохион байгуулах нийт сургалтад	Ерөнхий газраас зохион байгуулсан 11 удаагийн сургалтанд онлайнаар хэлтсийн мэргэжилтнүүд хамрагдсан.	

	байгуулах сургалтад тогтмол хамрагдана.			сургалтад хамрагдсан.	тогтмол хамрагдаж мэдээлэл авсан байна.	4 удаагийн онлайн сургалтанд гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын эмч мэргэжилтнүүдтэй хамтарч оролцсон. Ерөнхий газраас зохион байгуулсан 5 удаагийн мэдээллийн цагийн хөтөлбөрт хэлтсийн мэргэжилтнүүд бүрэн хамрагдсан.	100%
4.1.3	Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нээлттэй өдөрлөг, сургалт, сурталчилгааны бусад арга хэмжээг зохион байгуулна.	-	Зохион байгуулсан арга хэмжээ, сургалтын тоо	Зохион байгуулсан арга хэмжээ-3, сургалтын тоо-15	Сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, тайлагнасан байна.	ЭМД-ын ач холбогдлыг сурталчлах, хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор иргэдэд эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ И-БАРИМТ аппликэйшнээр хэрхэн шалгах төлөх талаарх мэдээллийг хэлтсийн нүүр номын хуудсаар дамжуулан хүргэж байна. Мөн хэлтэс дээр биечлэн ирж болон утсаар зөвлөгөө авсан 96 иргэнд шимтгэлээ И-БАРИМТ аппликэйшнээр хэрхэн шалгах төлөх талаарх мэдээллийг хүргэж газар дээр нь шимтгэлийг төлүүлж, өөрсдөө тухайн аппликэйшнийг ашигладаггүй даатгуулагчдад хэлтсийн мэргэжилтнүүд ибаримт сайтыг ашиглаж шимтгэлийг төлүүлж байна. Гэрээт эрүүл мэндийн байгууллагууд мөн аппликэйшн ашиглаж шимтгэл төлөх тал дээр иргэд даатгуулагчдад зөвлөгөө өгч ажиллаж байна. Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлын хүрээнд сумын ЗД-н тамгын газрын баг хамт олонд 2 удаа мэдээлэл хийж давхардсан тоогоор 80 гаруй хүнийг хамруулсан. ..... ширхэг хэвлэмэл хуудсыг гэрээт эрүүл мэндийн байгууллагуудаар тараж иргэд даатгуулагчдад сурталчилгааны хэвлэмэл хуудсыг ашиглаж мэдээ мэдээлэл өгч ажилласан.	100%
4.1.4	Байгууллагын үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг хангуулах	-	Иргэд, даатгуулагчдад хүргэсэн	ЭМДЕГ-ын фэйсбүүкийн пэйж хуудсанд	ЭМДЕГ-ын фэйсбүүкийн пэйж хуудсанд байршуулсан	Хэлтсийн фэйсбүүк хуудсаар эрүүл мэндийн даатгалын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, тогтоол, шийдвэр, журам, И-БАРИМТ аппликэйшн гар утсанд суулгах заавар сурталчилгаа болон	

	ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, иргэн-даатгуулагчид бодит мэдээ, мэдээлэл хүргэнэ.		мэдээлэл, хандалтын тоо	байршуулсан мэдээллийг түгээсэн хувь-90%, Хандалтын тоо -74695 Салбарын дагагчдын тоо-1190	мэдээллийг 90-ээс дээш хувь түгээж хандалтыг нэмэгдүүлнэ. ЭМДХ-ийн дагагчдыг нэмэгдүүлэнэ.	ЭМДЕГ-ын хуудсанд тавигдсан мэдээ мэдээллийг цаг алдалгүй тухай бүрд нь тогтмол пост оруулж иргэдийг мэдээ мэдээллээр хангаж ажиллаж байна. Тус хуудас нь энэ оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс хойш тодорхойгүй хугацаагаар хаагдсан байгаа. ОНХХ-тэй хамтран шалтгааныг олж хэвийн болгохоор ажиллаж байна. 2025 оны эхний 4 сарын байдлаар нийтдээ 223 мэдээ мэдээлэл постолсон нь 4215 хүнд хүрч, 53 удаа шэйрлэж, 15 хүн хариу сэтгэгдэл бичсэн байна. Одоогийн байдлаар хэлтсийн нүүр номын хуудас 1227 дагагчтай байгаа нь өнгөрсөн оныхоос 37 дагагчаар нэмэгдсэн. Хэлтсийн гадна талын мэдээллийн самбарыг тогтмол шинэчилж шинээр батлагдсан тушаал, тогтоол шийдвэрийг сурталчилж байна.	100%
4.1.5	Даатгуулагч-иргэд, гэрээт байгууллага, ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, түүний мөрөөр зохих арга хэмжээг авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлнэ.	-	Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо	151 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан.	Сэтгэл ханамжийн судалгаа авч, хэрэгжүүлсэн арга хэмжээний нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.	ЭМДЕГ-ын төрийн үйлчилгээний цахим шилжилттэй холбоотойгоор эрүүл мэндийн тусламж үйлчилгээг худалдан авах гэрээний хэрэгжилт, чанар төлбөрийн хяналт, цахим системийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор гэрээт 71 эрүүл мэндийн байгууллагуудын 265 эмч мэргэжилтнийг сэтгэл ханамжийн судалгаанд хамруулсан. Судалгаанд хамрагдсан эмч мэргэжилтнүүдийн 84,3% нь хэлтсээс эрүүл мэндийн даатгалтай холбоотой мэдээ мэдээллийг авдаг, 57,1% нь харилцаа хандлага сайн, 32,4% дунд гэж үнэлсэн байна. Нямзул эмнэлэгт үйлчлүүлж байгаа нийт 25 даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа авч дүгнэлтийг эмнэлэгт танилцуулсан. Судалгаанд хамрагдагсдын 10% нь орны хүлээгдэлтэй байна, эмнэлгийн орчин нөхцөл болон тусламж үйлчилгээний чанар, эмч ажилчдын харьцаанд 100% сэтгэл хангалуун байна гэж хариулсан байна.	100%

4.1.6	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд, үнэн зөв шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнана.	-	Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь	Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо 617, шийдвэрлэлт 100 хувь.	Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.	Хэлтэст 2025 оны 05 сарын 23-ны байдлаар 384 хүсэлт ирсэн байна. Ирсэн хүсэлтийг хугацаанд нь 100% шийдвэрлэж ажиллалаа. Нийт ирсэн хүсэлтийн 334 нь цахимаар, 21 нь утсаар, 29 нь биечлэн ирж уулзсан бөгөөд 87% нь төрсөн хүүхдийн бүртгэл мэдээлэл засуулах, 6,7% нь төр хариуцах хугацаа оруулах, 5,8% нь шимтгэл төлөлттэй холбоотой асуудлаар хандсан байна. Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудаас хэлтэст шууд хандаж ирүүлсэн албан тоот байхгүй. Хэлтсийн даргын хувьд аймгийн эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн комиссын гишүүнээр ажиллаж энэ онд нийт 2 удаагийн хурлаар 12 байгууллагын хүсэлтийг хянан шийдвэрлэж 10 байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгаж, 1 байгууллагад шинээр тусгай зөвшөөрөл олгож 1 байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцалж ажиллалаа. Мөн тус комиссын шугамаар 1 тосгонд 1 эмийн сан шинээр нээх хүсэлтийн дагуу газар дээрх үнэлгээг хийж тайланг комиссын хуралд танилцуулсан.	100%
4.1.7	Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдааны үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнана	-	Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	ЭМДЕГ-ын удирдлагуудын шуурхайгаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 10 удаа гаргаж хэрэгжилт 97.7 хувь. Даргын зөвлөлийн хурлын шийдвэрийн биелэлтийг	Удирдах дээд газраас өгөгдсөн үүрэг даалгаврыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.	Энэ он гарсаар ЭМДЕГ-ын шуурхай хуралдаанд 16 удаа онлайн-оролцож, шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн. Одоогийн байдлаар даргын зөвлөлийн хурлаас гарсан шийдвэр, орон нутгийн хэлтэстэй холбоотой хэрэгжүүлэх даалгавар хүлээж аваагүй байна.	100%

				хангаж тайланг ЭМДЕГ-т хүргүүлсэн.			
4.1.8	Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгавар, судалгааг хугацаанд нь үнэн зөвөөр гаргаж хүргүүлнэ	-	Үүрэг даалгавар, судалгааны тоо	ЭМДЕГ-ын газар хэлтсээс шаардсан цаг үеийн шинжтэй үүрэг даалгавар болон нийт 21 судалгааг хугацаанд нь холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн.	Удирдах дээд газраас өгөгдсөн цаг үеийн шинжтэй үүрэг даалгаврыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.	Он гарсаар ерөнхий газраас 3 удаагийн судалгаа, 2 удаагийн тоон мэдээ, 1 удаагийн зөвлөмжийн мэдээг шаардаж тухай бүр хугацаанд нь үнэн зөв гаргаж хүргүүлсэн. Мөн аймгийн статистикийн хэлтэст сар бүрийн 5-ны дотор гэрээт эрүүл мэндийн байгууллагуудаас нэхэмжилсэн болон олгосон санхүүжилтийн мэдээг хүргүүлдэг. Одоогийн байдлаар 5 удаагийн мэдээ хүргүүлээд байна. Энэ оны 5 сараас эхлэн энэхүү мэдээг гэрээт эрүүл мэндийн байгууллага болгоноор нэртэй нь гаргаж аймгийн ИТХ-д хүргүүлж байхаар болсон.	100%
4.1.9	Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилт, цаг бүртгэлд хяналт тавих, ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, зөвлөн туслах, чиглүүлэх, өдөр тутмын удирдлагаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	-	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөө, ГТ-ний биелэлтийн хувь	Хэлтсийн мэргэжилтэнгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж гүйцэтгэлийг хагас болон бүтэн жилээр дүгнэж ЭМДЕГ-т хүргүүлэн ажилласан.	Гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэсэн байна.	Хэлтсийн чанар, төлбөрийн хяналтын 2 мэргэжилтний 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг оны эхнээс жигд ханган биелүүлэхэд зөвлөн тусалж ажиллаж байна. 1 удаа явцын ярилцлага хийж дутуу гүйцэтгэсэн ажлуудыг сануулж хэлсэн. 05 дугаар сарын 12-ноос 1 чанар төлбөрийн хяналтын мэргэжилтэн хүүхэд асрах чөлөөнөөс ажилдаа орж тухайн мэргэжилтний гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж ерөнхий газарт хүргүүлсэн. Хэлтсийн байранд 2 чанар төлбөрийн хяналтын мэргэжилтэн ажиллаж эхэлсэн учир хийж гүйцэтгэх ажил үүргийг тэгш тэнцвэртэй хуваарилан, цагийн бүртгэлийг хянаж, өдөр тутмын удирдлагаар хангаж ажиллаж байна.	100%
4.1.10	Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж,	-	Архивын нэгжийн тоо (боть)	2024 онд 52 архивын нэгжийг бүрдүүлж,	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн	2024 оны ирсэн, явсан бичиг, 2024 оны ЭМД-н сангийн зардлын төлбөрийн баримтуудыг архивын нэгж болгон үдэж цэгцлэн хүлээлгэн өгөхөд бэлэн болгосон. / Нийт 44 боть баримт/	

	архивын нэгж бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.			албан бичиг хөтлөлийн анхан шатны баримтуудыг цэгцлэн ЭМДЕГ-ийн архивт хүлээлгэн өгөхөөр бэлтгэсэн.	дагуу архивын нэгжийг бүрдүүлсэн байна.	Хэлтэст эхний 11 сарын байдлаар нийт 112 албан бичиг, 17 дотоод албан бичиг ирж, 123 албан бичиг, 24 дотоод албан бичиг явснаас хагас жилийн тайлантай холбоотой 1 дотоод бичиг, 1 албан бичиг шийдвэрлэгдэх шатандаа байгаа бөгөөд үлдсэн бичгийг 100 хувь шийдвэрлэсэн.	100%																							
						<table border="1"> <thead> <tr> <th></th> <th>Бичгийн төрөл</th> <th>Хугацаандаа шийдвэрлэсэн</th> <th>Хугацаа хэтэрсэн</th> <th>Шийдвэрлэх шатандаа</th> </tr> </thead> <tbody> <tr> <td rowspan="2">Ирсэн албан бичиг</td> <td>Албан тоот</td> <td>112</td> <td>0</td> <td>1</td> </tr> <tr> <td>Дотоод бичиг</td> <td>17</td> <td>0</td> <td>1</td> </tr> <tr> <td rowspan="2">Явсан албан бичиг</td> <td>Албан тоот</td> <td>123</td> <td>0</td> <td>0</td> </tr> <tr> <td>Дотоод бичиг</td> <td>24</td> <td>0</td> <td>0</td> </tr> </tbody> </table>		Бичгийн төрөл	Хугацаандаа шийдвэрлэсэн	Хугацаа хэтэрсэн	Шийдвэрлэх шатандаа	Ирсэн албан бичиг	Албан тоот	112	0	1	Дотоод бичиг	17	0	1	Явсан албан бичиг	Албан тоот	123	0	0	Дотоод бичиг	24	0	0	
	Бичгийн төрөл	Хугацаандаа шийдвэрлэсэн	Хугацаа хэтэрсэн	Шийдвэрлэх шатандаа																										
Ирсэн албан бичиг	Албан тоот	112	0	1																										
	Дотоод бичиг	17	0	1																										
Явсан албан бичиг	Албан тоот	123	0	0																										
	Дотоод бичиг	24	0	0																										
4.1.11	Нийт албан хаагчдад Монгол бичгийн цахим гарын авлага-ыг таниулж хэрэглээнд нэвтрүүлэх, албан хэргийг хос бичгээр хөтлөх чадварыг дээшлүүлнэ.	-	Хэрэгжилтийн хувь	-	Албан хэргийг хос бичгээр хэрэгжүүлэн ажилласан байна.	Монгол бичгийн цахим гарын авлагыг судалж хэрэглээнд нэвтрүүлэх, албан бичгийг хос бичгээр хөтлөх бэлтгэл ажлыг ханган аймгийн архивын хэлтэстэй бичиг хэргийн ажил хариуцсан чанар төлбөрийн хяналтын мэргэжилтэн хамтран ажиллаж байна. 1 чанар төлбөрийн хяналтын мэргэжилтэн Удирдлагын академийн Монгол бичгийн анхан шатны цахим сургалтанд хамрагдаж үнэмлэх авсан. 1 чанар төлбөрийн хяналтын мэргэжилтэн Мандал сумын ЗДТГ-аас зохион байгуулсан монгол бичгийн 6 удаагийн сургалтанд хамрагдсан.	100%																							
4.1.12	Цахим гарын үсгийг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлнэ.	-	Цахим гарын үсгээр албажсан албан бичгийн тоо	-	Цаасан хэлбэрт байгаа мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх, илгээх, хүлээн авах, хадгалах	2025 оны 05 дугаар сарын 01-нээс цахим гарын үсгийг хэлстийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж түүнээс хойш хэлтсээс гарсан 35 албан бичгийг цахим гарын үсгээр баталгаажуулж илгээсэн байна.	100%																							

				үйл ажиллагаанд цахим гарын үсэг нэвтрүүлсэн байна.	Цахимаар баталгаажуулсан албан тоотыг албан бичгийн бүртгэлд дугаар өгч хөтлөн бүртгэлжүүлж байна.	
--	--	--	--	---	--	--

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт		Гүйцэтгэл хувь
		Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	
1	2	3	4	5
<b>2.1 Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх зорилтын хүрээнд</b>				
5.1	Агентлаг болон бусад байгууллага, төсөл хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдах арга зүйн сургалт, семинарт бүрэн оролцоно.	Сургалтад бүрэн хамрагдсан байна.	Авилгалтай тэмцэх газраас зохион байгуулсан 2 удаагийн онлайн, прокурорын ерөнхий газраас зохион байгуулсан 1 удаагийн зөрчлийн хэргийг онлайнгаар хэрхэн бүртгэх тухай танхимын сургалтанд хэлтсийн мэргэжилтнүүд бүрэн хамрагдсан. Хэлтсийн дарга аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан удирдах ажилтны зөвлөгөөнд оролцож, 2025 онд аймгийн засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулж 1 өдрийн сургалтанд хамрагдсан. Мандал суман дахь чанар төлбөрийн хяналтын мэргэжилтэн Глобал Удирдагч их сургуулийн "Эрүүл мэндийн менежмент"-ийн магистрийн хөтөлбөрт суралцан 34 кредит цаг биелүүлэн анагаах ухааны магистрын цол, диплом авсан. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нийгмийн бодлогын хорооны хуралд 2 удаа, аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд 2 удаа оролцож төлөөлөгчдийн асуусан эрүүл мэндийн даатгалтай холбоотой асуултанд хариулсан.	100%
5.2	Төрийн албан хаагчийн ёс зүй, удирдлагын манлайлал, хувь хүний хөгжлийн чиглэлээр танхимын болон онлайн сургалтуудад	Сургалт, семинарт бүрэн хамрагдсан байна.	Төрийн албаны зөвлөлийн 30 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан Дархан-Уул аймагт болсон бүсчилсэн 2 өдрийн "төрийн албаны манлайлал" сургалтанд хэлтсийн дарга оролцож, олон сонирхолтой сэдвээр мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн.	100%

	хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлнэ.		Төрийн албаны зөвлөлийн гишүүн, ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгсийн зохион байгуулсан "Ёс зүйтэй төрийн албан хаагч" сургалтанд хэлтсийн чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн хамрагдсан. 1 чанар төлбөрийн хяналтын мэргэжилтэн удирдлагын академийн дунд хугацааны сургалтанд өөрийн зардлаар суралцаж байна.	
--	--	--	---	--

Төлөөлөгөөг үнэлсэн:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

Төсвийн шууд захирагч

(С.ЭНХБОЛД)

(огноо)

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ  
ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА

Нэгжийн дарга

(Б.ОЮУНЦЭЦЭГ)

(огноо)  
2025.06.24

Тайлагнасан:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Нэгжийн дарга

(Ц.ДЭЛГЭР)

(огноо)  
2025.05.26

